## “БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
## 2021 ОНЫ 03 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр — Багануур дүүрэг

| № | ҮНДЭСЛЭЛ | ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ |
|---|---|---|---|
| 1. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.2 | БҮТП-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:<br>- Төрийн захиргааны төв байгууллагуудад хандах албан хэргүүдийг Нийслэлийн дээд шатны холбогдох байгууллагаар дамжуулан шийдвэрлүүлэх үүрэг чиглэлийн дагуу байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т хүргүүлсэн.<br>- НШУҮИГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох материалыг (технологийн түвшний үнэлгээ, ТЭЗҮ, паркийн хөгжлийн стратеги төлөвлөгөө, Байгаль орчны нарийвчилсан нөлөөллийн үнэлгээ) 03 дугаар сарын 22-ны өдөр НШУҮИГ-ын холбогдох мэргэжилтэн рүү хүргүүлсэн. | 100% |
| 2. | БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл | - Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, МУЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1.11.3, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2 дахь заалтын хүрээнд БХБЯ-ны захиалгаар Мон-Энержи Консалт ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгааны хэсгийг баталгаажуулах явцад хяналт тавьж байна.<br>- Паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугам болон үндсэн дэд станц болох 110/35кВ-ын зураг төслийг ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөж, нэмэлт өөрчлөлтийг оруулан баталгаажуулж байна.<br>- Паркийн үндсэн 110/35кВ-ын дэд станцаас Хүнд үйлдвэрлэлийн бүсэд байгуулагдах цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 35кВ-ын агаарын шугам болон 35/10кВ-ын “Төмөрлөг” дэд станцын зураг төсөлд БХБЯ-ны Барилгын Хөгжлийн төвийн экспертизийн өгсөн зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулан баталгаажуулахад бэлтгэж байна. | 100% |
| 3. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.4.5 | - Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн конструктор инженер компост бордоонд орох түүхий эдийг өвлийн улиралд бэлтгэх аргачлалын үр дүнг гаргасан. | 100% |
| 4. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам | Журмын дагуу дараах тайлангуудыг зохих газарт нь хүргүүлж ажилласан.<br>- Албан бичгийн шийдвэрлэлтийн тайлан<br>- Байгууллагын удирдлагын иргэдтэй уулзсан уулзалтын бүртгэл<br>- Өргөдлийн шийдвэрлэлтийн тоон мэдээ, тайлан | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ-аас 10/1049 дугаартай албан бичгээр ирсэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд нийцүүлэн Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-д өөрчлөлт оруулах төсөлтэй танилцаж, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 32 дугаартай албан бичгээр төсөлд оруулах нэмэлт санал байхгүйг уламжлан НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.<br>- Уг журам шинэчлэгдэж байгаатай холбогдуулан НЗДТГ-аас өгсөн чиглэлийн дагуу НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1 дүгээр улирлын биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 1 дүгээр улирлын дүнгийн товчоо, мэдээ, ХШҮ-ний тайланг дотооддоо гаргасан.<br>- Мөн НШУҮИГ-ын хөнгөн үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн /Буянтогтох/ рүү 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1 дүгээр улирлын биелэлт, 03 дугаар сарын 20-ны өдөр фото тайланг тус тус хүргүүлсэн.<br>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудтай байгуулах Хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний саналыг НЗДТГ-ын Хүний нөөцийн удирдлагын тасагтай зөвшилцөж, Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга /М.Аясгалан/-д 03 дугаар сарын 25-ны өдрийн 39 дугаартай албан бичгээр хүргүүлэв. | |
| 5. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж | - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- 2021 оны 03 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хариутай 5, хариугүй 11 нийт 16 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.13<br>- 2021 оны 03 дугаар сарын байдлаар "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 18 хариугүй бичиг явуулсан. Шийдвэрлэлт-100% | 100% |
| 6. | ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол | - Байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд баяжилтийг тогтмол хийж, ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байна.<br>- 2021 оны 03 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 5, цар тахалтай холбоотой 18 мэдээллийг байршуулсан.<br>- Байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд баяжилтийг тогтмол хийж, ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг ханган ажиллах талаар НЗДТГ-аас 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр ирсэн зөвлөмжийн дагуу арга хэмжээг зохион байгуулж, тайланг 03 дугаар сарын 31-ний өдөр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн. | 100% |
| 7. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль | - Байгууллагын 2021 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланг гаргах бэлтгэл ажлыг хանган ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | - www.shilendans.mn сайтад Байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна.<br>- Нийслэлийн төрийн аудитын газраас байгууллагын 2020 оны санхүү, НББ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр "Зөрчилгүй" дүгнэлт гаргаж гэрчилгээ хүлээн авсан. | |
| 8. | Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаал | - Захирамжлалын баримт бичгийг archive.mn программд оруулж дууссан.<br>- Ажилтнуудаас 2020 онд үүсч хөтлөгдсөн баримт бичгийг архивт хүлээн авах ажлыг дуусгасан.<br>- Албан хаагчдын архивт баримт хүлээлгэн өгсөн акттай баримт бичгийг тулган нэгдсэн бүртгэлийг гаргаж байна. | 100% |
| | | **НЭМЭЛТ АЖИЛ** | |
| 9. | НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 7 хоног тутам НЗДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хүргүүлэн ажиллаж байна. | | 100% |
| 10. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна. | | 100% |
| 11. | Хуулийн зөвлөх хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар байгууллагын ажилтнуудад 03 дугаар сарын 15-ны сургалт зохион байгуулсан. | | 100% |
| 12. | НШУҮИГ-н даргын тушаалаар "Парк хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэх" ажлын хэсэгт дарга Ч.Элбэгсайхан ажиллаж байна. | | 100% |
| 13. | 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр НШУҮИГ-аас зохион байгуулсан "Парк хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэх" ажлын хэсгийн цахим хуралд оролцож, хэлэлцсэн асуудлаар холбогдох саналуудыг тусгаж, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын мөн өдрийн 44 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т хүргүүлсэн. | | 100% |
| 14. | 2021 оны 03 дугаар сарын 15-17-ны өдрийн хооронд Smart UB аппликэйшн ашиглан Орон нутгийн хөгжлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх ажлын санал өгөхөд байгууллагын бүх албан хаагчдыг оролцуулж бүрэн хамруулсан. | | 100% |
| 15. | Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журманд нэмэлт өөрчлөлт оруулж Газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн А06 тушаалаар баталсан. | | 100% |
| 16. | Дээд газраас ирсэн тогтоол, захирамж шийдвэрүүд, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж байгууллагын дотоод хяналт шалгалтыг 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулав. | | 100% |
| 17. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 99 дүгээр захирамжаар батлагдсан "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан үйл ажиллагааг чиглэл болгон тусгай төлөвлөгөөг баталж, Жендэрийн үндэсний хорооноос Монгол цэргийн өдөр буюу 03 дугаар сарын 18-ны өдрийг тохиолдуулан өрнүүлж буй "Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна" аянд нэгдэн 03 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулсан арга хэмжээний тайланг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 33 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Соён гэгээрүүлэх тасагт хүргүүлсэн. | | 100% |
| 18. | Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, Спортын улсын хорооноос санаачлан зохион байгуулж буй "Эрүүл мэндийн цахим гүйлт – 2021" үйл ажиллагааны тухай нийт ажилтан албан хаагчдад танилцуулан "Багануур гүйгчид 2021" цахим хуудсанд нэгдэж STRAVA аппликейшн ашиглан цахим гүйлтийг зохион байгуулсан. | | 100% |
| 19. | Нийслэлийн архивын газраас 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан зохион байгуулсан "Албан хэрэг хөтлөлтийн Edoc системийн ашиглалт, ирсэн бичгийн шийдвэрлэлтэд анхаарах асуудал" сэдэвт цахим сургалтанд Захиргааны болон Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтнүүд, Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар оролцсон. | | 100% |

| | | |
|---|---|---|
| 20. | Дүүргийн удирдах ажилтнуудын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит /цахим/ шуурхай зөвлөгөөн дээр Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд зохион байгуулсан Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцсон тухай тайланг, 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдөр baganuurzaa@gmail.com цахим хаягт, 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 37 дугаартай албан бичгээр дүүргийн Захирагчийн ажлын албанд тус тус хүргүүлсэн. | 100% |
| | **ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД** | |
| 21. | Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100% |
| 22. | Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна. | 100% |
| 23. | Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна. | 100% |
| 24. | Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу ЗГ-ын 2021 оны 45 дугаар тогтоол, УОК-ын 2021 оны 18 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн биелэлтийг Багануур дүүргийн Онцгой комиссын шуурхай штабын даргын чиглэлээр бичиг хэргийн ERP хаягт өдөр бүр хүргүүлэн ажилласан. Ковид цар тахал нэмэгдэж байгаатай холбогдуулан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж байна. | 100% |
| 25. | ЗГ-ын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 тогтоолын хэрэгжилтийг заалт тус бүрээр хангаан ажиллаж байна. | 100% |
| 26. | Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/108, А/161, 221 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. | 100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНХЗАЯА